

“БАГШИЙН ХӨГЖИЛ” САЛБАР ХУРАЛДААНЫ ЗӨВЛӨМЖИЙН САНАЛ

Манай улсын их, дээд сургуулийн багшийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг шинжлэн үзсэний дүнд дор дурдсан зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нэг. Их хурал, Засгийн газарт хүргүүлэх санал, зөвлөмж

- Төрийн өмчийн их дээд сургуулийн багшийн статусыг тодорхой болгож “тэргүүлэх салбарын мэргэшсэн ажилтан (ТСМА)” гэсэн шинэ ангиллыг бий болгон энэ талаар төрийн албаны хуулийн холбогдох заалтад нэмэлт өөрчлөлт оруулах;
- Төрийн өмчийн их дээд сургуулийн багшийн сүлжээ, шатлалыг дэлхийн нийтийн жишиг ойртуулан шинэчлэн тогтоож, эрх зүйн орчинг шинэчлэх;
- Төрийн өмчийн их дээд сургуулийн хөгжүүлэх талаар төрөөс баримтлах үзэл баримтлалыг сургуулийн онцлогтой боловсруулж мөрдөх; Энэхүү үзэл баримтлалд “профессорт төвт их сургуулийн хөгжил”; “их сургууль ашгийн төлөө байх”; “их сургууль баялаг бүтээгч байх”; “их сургууль бизнесийн зарчмаар ажиллах” гэсэн зарчмыг тусгах;
- Дээд боловсролын багшийг бэлтгэх, хангах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бий болгож институтчилах эрх зүйн орчинг бүрдүүлэх.
- Жил бүрийн улсын төсөвт багшийн хөгжлийг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг суулгаж өгөх, тогтвортой нэмэгдүүлэх

Хоёр. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яаманд хүргүүлэх санал зөвлөмж

- Дээд боловсролын салбарт ажиллаж байгаа багшийн эрдмийн зэрэг, цолны нэмэгдлийг 3-5 дахин нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээ, олон нийтэд үзүүлсэн ажил, үйлчилгээнд хөлс тооцож олгох, тогтолцоог хуульчлан бүрдүүлэх;
- Их, дээд сургуульд профессорын багаар бие даан ажиллах /төсөв, санхүү, хүний нөөцийн бодлого зэрэг асуудлын хүрээнд/ эрх зүйн орчинг шийдвэрлэж өгөх;
- Багшийг насан туршид нь ажиллуулах асуудлыг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх;

- Дээд боловсролын салбарт ажиллаж буй багшийг мэргэшүүлэн бэлтгэх тогтолцоо бий болгож, тусгайлсан хөтөлбөрөөр сургалт явуулдаг болох замаар олон улсын зиндааны багшийн тоог нэмэгдүүлэх бодитой алхам хийх ажлыг яаралтай шийдвэрлэх;
- Их, дээд сургуулийн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт гаргаж мөрдөх;
- Дээд боловсролын салбарт ажиллаж буй багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх асуудлыг БСШУС-ын яамны хэмжээнд төвлөрүүлж, сонгон шалгаруулалтын үр дүнгээр нээлттэй, ил тод хэрэгжүүлдэг болох;
- Бүх их, дээд сургууль, коллеж багш нараа эрдэм чанарт буюу үйлийн судалгааны аргазүйд сурган, өөрсдийн сургалтын технологоо суралцагчдыг эрдэм чанарт буюу үйлийн судалгааны аргазүйд сургах ажлыг нэн яаралтай зохион байгуулж хэрэгжүүлэх

Гурав. Их, дээд сургуулийн удирдлагад өгөх зөвлөгөө, санал

- Тогтолцооны хандлага, боловсролын сэтгэл зүй, эмоцийн интеллект, тархи судлалын үндсийг баримтлан их сургуулийн багшийн хөгжлийн төв (ИСБХ)-ийг байгуулж тогтвортой ажиллуулах
- ИСБХ-ийн төвийн үйл ажиллагааг санал болгож буй загварын дагуу хөтлөн явуулах хүний нөөцийг бэлтгэх;
- Их сургууль хамтаар суралцагч байгуулага байх соёлыг төвөөр дамжуулан бий болгох;
- Оновчтой сонгон шалгаруулалт, тасралтгүй хөгжих бүтэц, бодлогыг санал болгож буй загварт тулгуурлан хийх;
- ИСБХ-ийн тасралтгүй хөгжлийг энэхүү төвийн үйл ажиллагааг тогтворжуулах замаар хангах
- Багш – хүний нөөц бүрдүүлэх, ажиллуулах, хөгжүүлэх асуудлыг урт хугацааны бодлого, төлөвлөлтөөр тогтвортой хэрэгжүүлж, олон улсын зиндаанд ажиллах багшийн тоог өсгөх;
- Багшийн академик эрх чөлөөг хангаж ажиллах;

Дөрөв. Их, дээд сургуулийн багшид өгөх зөвлөгөө, санал

- Судлаачийн чадвараа багшлахдаа хэрэглэх өргөн ашиглах¹;
- Педагогийг бус харин андрагогийг хичээл, сургалт хэрэглэх;
- Мэргэжилтний хэрэгцээ (чадамж)-ний өөрчлөлтийг анхаарч, өөрийн хөгжлийг хангах;
- Их сургуулийн багшийн арга зүйн хэт хуучинсаг хандлага (No1-ийн синдром)-ийг даван туулах;
- Их сургуулийн удирдлагад нийт багшийн хөгжлийн хангах чиглэлээр санал, санаачлага гаргах, тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоог бий болгохын чухлыг ухааруулах;
- Мэдлэгийн томъёоллыг туршиж үзэх, хамтрах, судалгаа хийх, өгүүлэл бичих
- ИСБХ төв тогтолцооны хэсэг болж тасралтгүй хөгжих боломжийг ашиглах;

Тав. Их, дээд сургуулийн оюутан төгсөгч, ажил олгогчид хүргүүлэх санал, зөвлөмж

- “Профессор багш их сургуулийн хичээлээр оюутанд эрдмийн дээд, ухааны дээжийн хүртээгч; шинжлэх ухааны салбар, хүн судлал, багшлах ухаан, багшлах урлагт мэргэжиж мэргэшсэн; оршиж буй он цагийнхаа соёл иргэншлийн сорыг тээгч, манлайлагч нэгэн байдаг” –тай уялдуулан өөрийн мэдлэг, чадвар, хандлагыг тасралтгүй хөгжүүлэгч мөнхийн оюутанг байх.

- ¹Scholarship of Teaching